



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн  
хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 2,500,000,000 /хоёр тэрбум таван зуун сая/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 600,000,000 /зургаан зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2. Энэхүү тогтоолын 1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудад хамаарахгүй болохыг дурдсугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотой одоо үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, үүнтэй холбоотой бусад зохицуулалтын саналыг боловсруулж 2016 оны 12 дугаар сард багтаан Хорооны хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН